



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 30 өдөр

Дугаар А/296

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн өмчит хуулийн этгээд “Урандөш зуслан” ОНӨҮГ-ын өмч хөрөнгө нь эвдэрч гэмтсэн тул хяналт, шалгалт хийх, тооллого явуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Г.Базар (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)

Ажлын хэсгийн гишүүд: Б.Болд (Аймгийн Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны албаны дарга)

Ч.Дашбаяр (Аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дарга)

Э.Пүрэвсүрэн (Аймгийн Санхүүгийн хяналт, шалгалтын улсын ахлах байцаагч)

Т.Амартүвшин (Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын нягтлан бодогч)

Нарийн бичгийн дарга: А.Энхжаргал (Аймгийн Орон нутгийн өмчийн газрын нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгжийн өмчийн бүртгэл, хяналт хариуцсан мэргэжилтэн)

2. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн өмч хөрөнгийн бүртгэлд хяналт тавьж, бүртгэл тооллогыг зохион байгуулж, дүнг 2023 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн дотор танилцуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Г.Базар)-д даалгасугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Мөнгөн-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ, ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ М.ХУЯГБААТАР



d/zahiramj

6711010383